▶クリックで音声再生▶

Монгол хэл
モンゴル語

まんがでわかる
倉庫業の安全衛生

КОМИКООР МЭДЭХ
Агуулахын үйл ажиллагааны аюулгүй байдал, эрүүл ахуй

Энэхүү дуу дүрст сургалтын материал нь агуулахын үйл ажиллагаа хийгдэх ажлын талбайд ажилладаг та бүхэнд зориулсан аюулгүй байдал болон эрүүл ахуйн үндсэн мэдлэг олгоход зориулан боловсруулсан материал болно.

Үйлдвэрлэлийн ослын улмаас хохирсон хүмүүсийн байдал

1	Үйлдлийн хариу үйлдэл, хүчилсэн үйлдэл	151 хүн (22%)
2	Ойчих	143 хүн (21%)
3	Өнхөрч унах, өндрөөс унах	94 хүн (14%)
4	Хавчуулагдах, ороцолдох	86 хүн (13%)
5	Цохиулсан	61 хүн (9%)

Нэмэлт: Эрүүл мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны Ажлын байрны аюулгүй байдлын сайт "Ажилчдын хохирлын тайлан"-н Хохирол гамшгийн статистик мэдээлэл (2020 оны батлагдсан утга) (Ослын тохиолдлын эзлэх хувийг 2020 онд гарсан бүх тохиолдолтой (685 осол) харьцуулан гаргасан)

Тийм байна.

Жишээлбэл, “Үйлдлийн хариу үйлдэл, Хүчилсэн үйлдэл” байх тохиолдолд

ачаа зөөх болон өргөхдөө нуруу болон мөр, гар зэрэгт гэмтэл авсан гэх тохиолдол гарч байгаа.

Ялангуяа хүнд ачааг өргөх үед болон ачаа барьсан байдалтайгаар биеийн байрлалыг өөрчлөх үед нуруугаа гэмтээхэд хялбар байдаг тул анхаарах хэрэгтэй.

Цаасан хайрцгийг хараад хүнд жинг нь мэдэх боломжгүй тул болгоомжтой байх хэрэгтэй.

Ложистик нэмэгдээд ачаа орох гарах хэмжээ нь нэмэгдэж байгаа нь ч холбоотой байж болох юм.

Хэрхэн сэргийлдэг юм болоо?

Тухайн хүний анхаарал болгоомж бол мэдээжийн хэрэг бөгөөд, тогтоосон дүрэм болон ажлын дарааллыг баримтлах нь чухал шүү.

Олон дүрэмтэй байх төвөгтэй юм аа...

Гол нь болгоомжтой байхад болох юм биш үү?

Юу?

Төвөгтэй байсан ч өөрийгөө болон бусдыг хохироохгүй байх нь чухал!

З, Зааа!

Дараагийнх нь "Ойчих". Нэг удаад их хэмжээний ачааг зөөх үед, хөл доорх бартаа саадыг анзааралгүй тээглэж унах тохиолдол олон байдаг.

Ялангуяа, агуулахын орох гарах хаалга орчимд поддон зэрэг нь тавиастай байх нь олон байдаг тул анхааралтай байх шаардлагатай юм шүү.

Гэмтэл авч ажил хийх боломжгүй болбол ар гэрийнхэн нь ч санаа зовж, өрхийн орлого ч бас хүнд болно...

Тийм ч учраас энгийн үед ч анхааралтайгаар үйл хөдлөл хийх нь маш чухал юм.

Ачаа зөөх үед өмнөх зүйлээ харж чадаж байхаар зөөхийн зэрэгцээ өндрийг ч анхааран үзэж, тавцант тэрэг зэргийг ашиглана. Цаашлаад эргэн тойрондоо анхаарал хандуулна.

Зөв барих арга, зөөх арга, нурууны гэмтлээс сэргийлэхэд ч ач нөлөөтэй тул чухал юм.

“Өнхөрч унах, өндрөөс унах” нь ямар үед бий болж байна?

Жишээлбэл, поддонт тавиурын ачааг шалгаж үзэх гээд,

тавиур уруу авирахад гар халтираад унасан тохиолдол байдаг.

Аанхаа....

Тэгэхээр дараа нь,

ガーッ

カチッ...

おお

Бодит ажлын талбайг,

1

ジジ

харцгаая!

CASE 1

Энэ хоёр хайрцгийг тийш нь зөөгөөд өг.
За!

Ийм хэмжээтэй хайрцаг юм бол хялбархан зөөчих юм шиг байна.


Тэх!
Пүү!


Гэхдээ тавцант тэрэг ашиглаад байхаар ч хүнд биш юм байна...

За ингээд!
...!!

Яааяя...
Нуруугаа өвтгөчхөв үү?

Хэн нэгнийг дуудаад өгөөч!


Нуруу өвдөөд байна!
Хүчилсэн байрлалаар өргөснөөс болсон уу?

Зүгээр үү?
Хаана өвдөж байна?
Нуруугаа гэмтээсэн байж магадгүй.

Үлдсэнийг нь би хийх болохоор амарч бай.

しって…
Оффист амарч байх уу.

Ганцаараа хийх болохоор бөөнд нь зөөсөн нь үр дүн сайтай юм байна.


Хоёрыг нийлүүлээд.

Ингээд явъя!

Хөл доорх харагдахгүй байгаа ч энүүгээрээ зөөгөөд дуусгачихъя.



Ааа!

パーン

Яаа!

Яасан бэ!?

CASE 2


カッ

Өнөөдөр халуун байна, халуунд цохиулахаас болгоомжлоорой.


Хоёр дахь тавиурт байгаа тэр ачааны дугаарыг шалгаад өг.
За.

ぼーー
はぁはぁ

Царайны өнгө сайнгүй байна, зүгээр үү?
Зүгээр ээ.

Шатыг сайтар ашигла.
За!

Гэхдээ….

Шат байгаа газар хүртэл хол байна шүү...

Шат авч ирэх нь ядаргаа.
ガッ

Энэ зэргийн өндөрт бол шат байхгүй байсан ч авирч чадна.

Энд байгаа тоо
зөв байна.

Дараа нь энэ
хайрцгийг шалгая.






Зүгээр бай!
Яасан!?

Халуунд цохиулсан байж магадгүй.
Сэрүүхэн газар луу явцгаая.

Тийм үү, ажлын өмнө байдал муу байсан байх нь ээ. Толгойгоо цохиогүй биз?
Тийм. Толгойгоо цохиогүй.

Биеийн байдал муу байгаа бол заавал мэдэгдэх.
Өндөр газар ачааг шалгахдаа аюулгүй ажиллах дүрмийг баримтлан шат болон А шат ашиглах.
Багана уруу авирч болохгүй шүү.

Өндөр газар ажиллах үед унах эрсдэл байдаг юм байна.
За.

Чи ч бас найзын чинь бие муу байгаа үед амрааж байх хэрэгтэй.
З,Заа!
Ялангуяа халуун улиралд халуунд цохиулахад амархан байдаг.

Гэмтэл бэртэл авбал гэр бүл нь санаа зовно шүү.
Болгоомжтой байх болно.

CASE 3




По өргөгчийн жолоодлогод ч нэлээн даслаа даа...
Тээврийн ажил ч одоо юүхэн байхав. Хурдхан дуусгана аа!


Эргэн тойрноо шалгаарай!
Зааа.


ピピー
キキッ
ウィーン



Өө, чухал падааныг мартчихсан байна.

Аа! Зүгээр л тэнд байсан юм байна!

Уучлаарай! Падаан мартсан байна!

Юу?

Аюултай! Тэрүүгээр гарч болохгүй!

ウィィ…

!!

ピピピピ

ウィィィィン

Юу!?

ムッ

Aaaa!

キキッ

キキィ


Яагаад ийм газар байгаа юм бэ! Энэ бол нэвтрэх хориотой бүс шүү дээ!

Уучлаарай.


Зүгээр үү?
Бэртэж гэмтсэн үү?

Нэвтрэх хориотой бүсэд яасан ч орж болохгүй.
Яарч байсан ч заасан зорчих хэсгээр явж бай.

Чи ч бас болгоомжтой байхгүй бол болохгүй.


Ар талаа шалгасан уу?

Эргэн тойрон дахь нөхцөл байдлыг шалгахгүй байх нь осолд хүргэдэг.

Дүрмийг дагаж мөрдөх нь ажлыг хөнгөвчлөх бөгөөд өөрийгөө хамгаалах зүйл болдог юм.
За!



Агуулахын үйл ажиллагаанд анхаарууштай гол санаа

1 Хүнд эд зүйлс

Ачааг зөөх үед нурууны өвдөлт зэргээс сэргийлэхийн тулд жин болон оврыг анхаарцгаая.

2 Хөл доорх

Ачаа зөөхдөө ойчихоос сэргийлэхийн тулд ойр орчмын харагдцыг анхаарцгаая.

3 Өндөр газар

Өндөр газар ажиллахдаа унахаас болгоомжил.

4 Нэвтрэх хориотой бүс / По өргөгч



Нэвтрэх хориотой бүс болон по өргөгчийн хажуугаар яагаад ч явахгүй байцгаая.

Агуулахын үйл ажиллагаа

Энэ зүйлд ч анхаарцгаая!

Аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөөх зөвлөмж!

1 Нурууны өвдөлтөөс сэргийлэх жингийн хязгаарлалт

Хүнд ачаа өргөхдөө эрэгтэй нь биеийн жингийн 40%, эмэгтэй нь 24%-с илүү хүнд зүйлийг хүний хүчээр зөөж болохгүй.
(Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгаалллын Яам Ажлын байран дахь нурууны өвдөлтөөс урьдчилан сэргийлэх удирдамжаас)

2 Хамгаалалтын малгай (дуулга) өмсөх

Агуулахад аюулгүй ажиллахын тулд заавал дуулга өмсөх. Халуун байна гээд дуулгаа бүү тайл.

3 А шат / шатны ашиглах арга

Шатны оройд сууж, А шат болон шатны хөлийг хөдөлгөөнтэй газар тавихгүй байх зэргээр анхаарна.

* Дэлгэрэнгүйг "Комикоор мэдэх Аюулгүй байдал эрүүл ахуй болон үйлдвэрлэлийн ослоос сэргийлэхийн үндэс (Дундын сургалтын материал)"-с харах

4 Халуунд цохиулах

Халуун улиралд агуулах дотор халуунд цохиулахаас болгоомжил. Бие муу болбол нэн даруй мэдэгдээрэй.

* Дэлгэрэнгүйг "Комикоор мэдэх Аюулгүй байдал эрүүл ахуй болон үйлдвэрлэлийн ослоос сэргийлэхийн үндэс (Дундын сургалтын материал)"-с харах

Зургаар суралцах

Ажлын талбар дээр ажиллаж байхад нуугдах эрсдэлийг мэдэцгээе!

Аюулыг урьдчилан таних сургуулилт (АУТС)

Q Асуулт: Хаана аюултай вэ гэдгийг бодоорой!



A Хариулт: Энэ бол аюулын үндэс!



1. Орох гарах хаалга орчмыг эмх цэгцтэй эмх дараалалтай болгож, бүдэрч унахгүй байхад анхаарах.

2. Хөл доорход анхаарах.

3. Ажиллаж буй по өргөгчид ойртохгүй.



Өөр аюул ослын цэг байгаа эсэхийг бодоорой.

КОМИКООР МЭДЭХ

Агуулахын үйл ажиллагааны аюулгүй байдал, эрүүл ахуй

2022 оны 3-р сарын хэвлэл

Хэвлүүлсэн: Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яам

Төлөвлөн хэрэгжүүлсэн: Mizuho Research & Technologies, Ltd.
Хамтран ажилласан: Бөөний худалдаа, агуулахын үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдлын боловсрол сургалтын материал боловсруулах ажлын хэсэг
Хэвлэсэн: Sideranch Inc.

厚生労働省
Ministry of Health, Labour and Welfare

Энэ материалтай холбоотой холбоо барих

Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яамны
Хөдөлмөрийн стандартын товчооны
Аюулгүй ажиллагааны хэлтэс,
Аюулгүй байдал, эрүүл ахуйн газар